

# Contents

- 2 日本語版
- 4 Bản tiếng Việt [ベトナム語版]
- 6 中文版 [中国語版]
- 8 Bersyon sa Pilipino [フィリピン語版]
- 10 Edisi Bahasa Indonesia [インドネシア語版]
- 12 ฉบับภาษาไทย [タイ語版]
- 14 ភាសាខ្មែរ [カンボジア語版]
- 16 မြန်မာဘာသာ မူ [ミャンマー語版]
- 18 Монгол хэл дээрх хувилбар [モンゴル語版]
- 20 English Version [英語版]

## こくごのもり

小学低学年の児童を対象に国語の楽しさを知ってもらおうと、イラストを多用してつくった問題で「毎日小学生新聞」に長期連載。

©毎日小学生新聞 複製、転用はできません



答えはP22にあります。

# Ур чадварын дадлагажигчийн анд нөхөр

2022 оны 1 дугаар сар, Өвлийн дугаар

## Газар хөдлөлт болоход үзүүлэх хариу үйлдлийн талаар мэдэж авцгаая

Япон нь газар хөдлөлт ихтэй орон. Өнөөг хүртэл, 1995 оны 1-р сарын 17-ны “Ханшин-Аважигийн их газар хөдлөлт”, 2011 оны 3-р сарын 11-ны “Зүүн Японы их газар хөдлөлт” зэрэг олон хүн нэрвэгдсэн, их хэмжээний газар хөдлөлт болж байсан. Газар хөдлөлт хэзээ болох нь мэдэгдэхгүй. Газар хөдлөлт болоход үзүүлвэл зохих хариу үйлдлийн талаар мэдэж аван, байнга сэтгэлзүйн бэлтгэлтэй байж, ойр орчмынхоо бэлтгэлийг базаагаарай.

### [1] Гарц бий болгох

Байшин барилга нурвал, хаалга, цонх нь нээгдэхгүй болдог. Газар хөдлөлт болоход байнга бэлтгэлтэй байж, гадагшаа дүрвэхэд ашиглах дүрвэх гарцтай байхыг хичээгээрэй.

### [2] Биеэ хамгаалах

Хүчтэй чичиргээ мэдрэгдвэл, даруй бат бөх ширээний доор орж биеэ хамгаалаарай. Унтаж байхад тань газар хөдөлвөл хөнжил, дэр зэрэг юмаар толгойгоо хамгаалж, дээрээс унаж ирэх юм, нурж ирэх юмнаас болгоомжлоорой.

### [3] Гал унтраах

Чичиргээ мэдрэгдвэл даруй хэрэглэж байгаа галаа унтраагаарай. (Чичиргээ хүчтэй бөгөөд биеэ хамгаалах шаардлагатай бол, чичиргээ намдсаны дараа галаа унтраана.) Өөрөө галаа унтраах боломжгүй тохиолдолд, даруй 119 дугаар (Гал команд) руу залгаарай.


### [4] Цунамигийн аюул байгаа эсэхийг нягтлах

Телевиз, радиогоор газар хөдлөлтийн талаар мэдээлэл олж авахын зэрэгцээ цунами дайрах аюул байгаа эсэхийг нягтлаарай. Газар хөдлөлтөөс улбаалсан цунами бол маш хурдан бөгөөд аюултай давалгаа юм. Далай, гол мөрний ойрхон байгаа бол даруй өндөрлөг газар руу дүрвээрэй. Цунами нь зөвхөн далайгаас бус голоос ч ирдэг.

### [5] (Цунамигийн аюул байхгүй тохиолдолд) Яаран гадагшаа гарахгүй байх

Газар хөдлөлтийн үед яаран гадагшаа гарвал, хагарсан цонхны шил, хаяг самбар дээрээс унаж ирэх тохиолдол байдаг ба яаран гадагшаа гарах нь илүү аюултай. Гэртээ юм уу байшин барилгын дотор байгаа тохиолдолд, эргэн тойрноо сайтар нягталж, сандарч тэвдэлгүйгээр хөдлөөрэй. Мөн хүчтэй газар хөдлөлтийн дараа хэд хэдэн удаа чичиргээ үүсэх тохиолдол байдаг.

Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага (ОТІТ)-ын цахим хуудаснаас нийслэл хот болон мужуудын гамшгаас урьдчилан сэргийлэх талаарх мэдээллийг та эх хэл дээрээ унших боломжтой тул сонирхож хараарай.

 <https://www.otit.go.jp/disaster/>

Энэхүү нийтлэлийг ч “Ибараки мужийн гамшгийн үеийн заавар”-ыг үндэслэн JTCSO-гоос боловсруулсан болно.



### Мэдээлэл олж авахад

Гамшгийн үед мэдээлэл хэрэгтэй байдаг. Телевиз, радио, интернет зэргээр хамгийн шинэ мэдээллийг дамжуулдаг.

#### ◆Газар хөдлөлтийн урьдчилан сээрэмжлүүлэх шуурхай мэдээ

Газар хөдлөлтийн хүчтэй чичиргээ үүсэхийн өмнө телевиз болон радио, гар утаснаас тусгай дохиолол цацагддаг. Энэ дохиоллыг сонсвол, юуны өмнө газар хөдлөлтөөс биеэ хамгаалж, сандарч тэвдэлгүйгээр аюулгүй газар руу дүрвээрэй.

#### ◆Телевиз

Гамшгийн үед, мэдээгээр хамгийн шинэ мэдээллийг дамжуулдаг. Дата мэдээллийн нэвтрүүлгээр тухайн бүс нутаг тус бүрийн талаарх мэдээллийг дамжуулдаг.

#### ◆Радио

Цахилгаан тасарсан үед ч сонсох боломжтой, батерейгаар ажилладаг радио маш их хэрэг болдог. Радиогийн нэвтрүүлгийг интернетээр ч сонсох боломжтой тохиолдол байдаг.

★Эх сурвалж: Вакаяма мужийн Олон улсын харилцааны төв, Гамшгаас урьдчилан сэргийлэх гарын авлага

## JITCO-гийн Япон хэлний зохион бичлэгийн уралдаанд хүчээ сорьцгооё

JITCO нь жил бүр “Ур чадварын дадлагажигч гадаад иргэд, сургалтанд хамрагдагчдын Япон хэлний зохион бичлэгийн уралдаан”-ыг зохион байгуулдаг. 2022 оны Япон хэлний зохион бичлэгийн уралдааны удирдамжийг JITCO-гийн цахим хуудсаар 2-р сарын үед мэдээлэхээр товлож байна. Та бүхнийг идэвхтэй оролцохыг урьж байна!

### Зохион бичлэг бичиж хүчээ сорьцгооё!

#### ⇒Нэг зүйлийн талаар сонгож бичих

Та бүхэн Японд ирээд хөгжөөнтэй явдал, гунигтай явдал, гайхах зүйл, хүнд хэцүү санагдах зүйл гээд өдөр бүр янз бүрийн юм үзэж туулж байгаа болов уу. Зохион бичлэг бичихдээ, олон үйл явдлынхаа дотроос нэг зүйлийг сонгоорой. Юу болсон, хэн юу гэж хэлсэн, та өөрөө юу гэж бодсон гэх зэргээр тодорхой бичвэл бодол санаа тань уншигчдад хүрнэ.

#### ⇒Танаас өөр хэн ч бичиж чадахгүй зүйлийн талаар бичих

“Японы зам нь их цэвэрхэн.” гэх мэт хялбар өгүүлбэрээр бичих бус, тухайлбал, “Японы зам нь цэвэрхэн байдгийн учрыг ажлын газрынхаа хүнээс асууж үзлээ.” гэх мэтчилэн өөрийнхөө тодорхой туршлагатай холбоод бичиж үзээрэй.

#### ⇒Сэдвээ сайн бодож байж өгөх

Унших хүндээ “Энэ юуны тухай зохион бичлэг юм бол?” гэж бодуулахуйц, таны бүтээлийг уншиж үзэх сонирхлыг нь өдөөхүйц сэдэв өгөөрэй.



Өмнөх онуудын Япон хэлний зохион бичлэгийн уралдааны шагналт байранд орсон бүтээлүүдийг дараах сайтаас харах боломжтой.

<https://www.jitco.or.jp/ja/service/competition.html>

## Мангагаар дамжуулан мэдэж авцгаая, Япон хүний сэтгэл

— Бэлтгэлтэй бай! —



### Маруй сан, зүгээр өнгөрсөнд санаа амрав

Газар хөдлөлт үүссэний дараа юуны өмнө амиа хамгаалахын тулд, дүрвэх нь маш чухал гэдгийг хүн болгон мэддэг. Гэтэл, хамгийн их анхаарах хэрэгтэй зүйлийн талаар хүмүүс тэр болгон мэддэггүй. “Бэлтгэлтэй байхад сандарч тэвдэх юм огт үгүй.” гэдэг үг ч байдаг. Юутай ч, та бүхэн ч гэсэн байнга бэлтгэлтэй байж, мэдлэгтэй байхыг хичээгээрэй.

◆こくこたえ



小さな点も、漢字の大事な一画です。一つでなく、「雨」や「点」のように四つも点がつく漢字もあります。
「下」は、おおいの下に黒い点をつけて、下に物があることを示した字です。
同じ点でも、「馬」の「」は四本の脚です。
「楽」は、「木の実を振って鳴るのを楽しんだから」とも、「病気を払うために、枝を振っておほらいをしたから」とも考えられています。楽にしてくれる草が薬です。

Trong chữ Hán, chỉ một nét phẩy nhỏ cũng là một bộ phận quan trọng. Có chữ chỉ có một nét phẩy nhưng cũng có những chữ cần tới 4 nét phẩy, ví dụ như chữ “雨” (mưa) hoặc chữ “点” (điểm). Trong chữ “下” (dưới) thì người ta thêm nét phẩy vào dưới chữ mang nghĩa mái che để nói rằng phía dưới đó có đồ vật. Cũng là nét phẩy, nhưng trong chữ “馬” (ngựa) lại mang nghĩa là 4 chân của con vật. Còn trong chữ “楽” (vui vẻ) thì mang nghĩa là “vui vẻ rung cho trái cây rung rinh” hoặc “rung cành cây để xua đuổi bệnh tật khiến ta vui vẻ”. Cỏ mà làm cho chúng ta thấy thoải mái khỏe mạnh thì đó là “薬” tức là “thuốc”.

小小的点，作为汉字也是重要的一个笔画。不一定是一个点，也有像“雨”、“点”这样带有四个点的汉字。“下”字，盖罩的下方加一黑点，这汉字表示下面有东西。即便是相同的点，“馬”的“、”表示的是四条腿。“楽”既可以认为是“因为享受了摇晃树木果实而发出的声响”，也可以认为是“为了驱除疾病，摇动树枝进行了驱邪”。能让人放松的草则是药。

Ang isang maliit na parang tuldok ay mahalaga rin sa stroke ng kanji. Hindi lamang isa,tulad ng 「雨」 at 「点」 na may apat ding stroke na tuldok sa kanji. Ang 「下」 ay, ang isang itim na tuldok ay inilagay sa ilalim upang ipahiwatig na may isang bagay na nasa ilalim. Sa parehong tuldok, ang “、”ng 「馬」 ay may apat na paa. Ang 「楽」 ay maaaring sabihin din na "dahil nasiyahan akong iwagayway ang mga mani at tugtog" at "dahil inalog ko ang mga sanga upang mawala ang aking karamdaman."

Ang damong nagpapagaan sa iyong pakiramdam ay isang gamot. (raku ni shite kureru kusa ga kusuri desu).
Dalam huruf Kanji, sebuah titik kecil pun merupakan goresan penting. Beberapa huruf Kanji memiliki bukan hanya satu, melainkan empat titik, seperti “ame (hujan)” dan “ten (titik)”. “Shita (bawah)” adalah huruf dengan titik hitam di bawah penutup untuk menunjukkan bahwa ada sesuatu di bawahnya. Pada titik yang sama, tetapi “、” dari “uma (kuda)” artinya empat kaki. “Gaku (musik)” dianggap sebagai “merasa senang karena bunyi biji-biji pohon yang diguncang-guncang” dan “menggoyang-goyangkan dahan untuk mengusir penyakit”. Rumput yang membuatmu merasa “raku (lebih baik)” adalah “kusuri (obat)”.

แม้จะเป็นจุดเล็ก ๆ แต่ก็เป็นส่วนที่สำคัญในตัวอักษรคันจิ ไม่ใช่แค่คันจิที่มีหนึ่งจุด แต่มีทั้งคันจิที่มีถึง 4 จุดอยู่ในตัวอักษร เช่น 「雨」 และ 「点」 คำว่า 「下」 ในจุดดำใต้ส่วนที่ปกคลุม เป็นตัวอักษรที่แสดงถึงการมีสิ่งของอยู่ใต้นั้น ในอักษร 「馬」 จุดอันเดียวกันนี้ 「、」 คือขาทั้ง 4 ข้างของม้า สมมติฐานได้ว่า 「楽」 นำมาจาก “การเขย่าผลไม้ให้มีเสียงสร้างความสนุกสนาน” หรือ “การกวัดแกว่งกิ่งไม้เพื่อขับไล่โรคภัยไข้เจ็บ” ดังนั้น ต้นหญ้าที่ทำให้สบาย (楽) ก็คือยา (薬) นั่นเอง

ចំណុចតូចមួយ ក៏ជាចំណុចសំខាន់នៃអក្សរកាន់ជិផងដែរ។ អក្សរកាន់ជិខ្លះ មិនមែនមានតែមួយទេ គឺមានចំណុចដល់ទៅបួនដូចជា “雨” និង “点” ជាដើម។ “下” គឺជាអក្សរដែលមានចំណុចខ្មៅនៅក្រោមគម្រប ដើម្បីបង្ហាញថាមានអ្វីមួយនៅខាងក្រោម។ ដូចគ្នានេះផងដែរ “、” នៅក្នុងអក្សរ “馬” គឺជាជើងទាំងបួន។ អក្សរ “楽” ត្រូវបានគេយល់ថាជា “ដោយសារតែ រីករាយនឹងការត្រូវផ្លែឈើហើយលឺសម្លេងរោទិ៍” ឬ “ដោយសារតែការអង្រែមែកឈើ ដើម្បីកម្ចាត់ជំងឺ” ។ ស្មៅដែលធ្វើអោយអ្នកមានអារម្មណ៍ធូរស្រាល (楽) គឺជាថ្នាំ (薬) ។

အဝက်လေးတစ်ဝက်ဟာလည်း ခန်းဂျီးစာလုံးမှာ အရေးပါတယ်။ 雨 နဲ့ 点 လို ၄ ဝက်ပါတဲ့ ခန်းဂျီးလည်းရှိပါတယ်။ 下 ဆိုတာ အကာအောက်မှာ အမည်းဝက် ရေးပြီး အောက်မှာပစ္စည်းရှိကြောင်းပြတဲ့ စာလုံးပါ။ အဝက်ဆိုပေမဲ့ 馬 ရဲ့အဝက်ကတော့ခြေလေးချောင်းပါ။ 楽 ဆိုတာ “သစ်စေ့ကို အသံမြည်အောင်လှုပ်ပြီး ဆော့ခွဲလို့” “ရောဂါကင်းအောင် သစ်ကိုင်းကိုဝှေ့ဖမ်းမုန်းမှုတ်ခွဲလို့” စသဖြင့်ယူဆကြပါတယ်။ သက်သာအောင်လှုပ်ပေးတဲ့နွယ်မြက်ဆိုတာ ဆေးဖြစ်ပါတယ်။

Жижигхэн зураас ч гэсэн ханзны чухал зурлагуудын нэг нь. Ганцхан зураас биш, “雨/ame/бороо”, “点/ten/цэг” гэх мэт ханзнууд шиг 4 зураастай ханз ч байдаг. “下/shita/доор” нь “おおい/ooi/бүрхүүл”-ийн доор “黒い点/kurio ten/хар цэг” тавьж, доор нь юм байгааг илэрхийлсэн ханз юм. Ижилхэн зураас боловч, “馬/uma/морь” гэдэг ханзны “、” бол 4 хөлийг нь илэрхийлж байгаа юм. Харин “楽/tanoshii/хөгжилтэй,raku/амар” бол, “木/ki/мод”-ны жимсийг сэгсэрч дуу гарахыг нь сонсож баясахаас гаралтай гэж ч, “Өвчнийг үргээхийн тулд, модны мөчрийг сэгсэрч өвчнийг зайлуулахаас гаралтай” гэж ч үздэг. “楽/raku/амар” болгож өгдөг “草/kusa/өвс” нь “薬/kusuri/эм” юм.

Even small dots are important strokes in kanji. Some kanji, such as “雨” and “点,” have as many as four dots. “下” has a black dot under a covering to express that something is placed under or at the bottom of something. A dot may represent many different things. In “馬,” the four dots represent the four legs of a horse. In “楽,” which means “fun,” the dots are said to represent nuts, because people had fun shaking nuts to make a sound. This kanji also means “relief,” and the dots are said to represent branches in this case, because branches were waved as part of a rite to ward off illness. The kanji for medicinal drug (薬) combines “楽” (relief) and “草” (plant), because drugs are plants that provide relief.

技能実習生・研修生向日本語情報誌 発行 公益財団法人 国際人材協力機構 (JITCO)
技能実習生の友 総務部広報室
2022年1月 冬季号 〒108-0023
2022年1月1日発行 東京都港区芝浦2-11-5
電話 50嵐ビルディング 03-4306-1166 (ダイヤルイン)
JITCO ホームページ https://www.jitco.or.jp/